

МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН МЭДЭЭ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Дуулгавартай байдал

Далын ахлагч Визит Канахам

Олон нийтэд танигдаагүй, Оус болон цахилгааны хангамж муутай жижигхэн тосгонд би төрсөн юм. Энэ нь Тайландын хойд хэсэг дэх Чиангмай аймгийн Тэмбон Сэнпүүлү Дүсэкэд дүүргийн Бэн Понг гэдэг газар байв. Хөдөөний л нэг хүүгийн адил би цагаан будааны талбайгаар гүйж, мал хариулан мөн шашнаа чанд баримталдаг фермчин гэр бүлд арвич хямгач амьдрах хувийн сахилга баттай өссөн.

Би 63 жилийн өмнө 4 настай байсан тэр үеэсээ эхлэн орон нутгийн сургуульд явахын тулд 2 километр алхах ёстой байлаа. 8-аас 11 нас хүртлээ улсын сургуульд явахын тулд дөрвөн километр алхдаг байв. Тэгээд улсын дунд сургуульд явж, дараа нь ахлах сургуулийн боловсролоо хувийн сургуульд эзэмшсэн юм. Би Рэмханханг Их сургуульд үргэлжлүүлэн суралцаж, англи хэлний мэргэжил эзэмшсэн бөгөөд эдийн засгийн чиглэлийг дагалдах хичээлээ болгон суралцаж төгссөн юм.

Амьдралынхаа турш би олон нийтэд хандсан үйлчлэлийн төсөл дээр ажиллах дуртай байлаа. Их сургуульд байхдаа Англи хэлний клубийн өмнөөс Англи хэл, Америкийн утга зохиолын курсуудад сайн дурын зааварлагч хийдэг байв. Тэр цагаас хойш хувийн сургууль, коллеж, улсын мэргэжлийн коллеж болон улсын асрамжийн сургуульд англи хэл зааж

байна. Үүнээс гадна манай гэр бүл Тайландын өмнөд хэсгийн Тран аймаг дахь Техникийн ба Сувилахуйн коллежийн оюутнуудад зориулсан Англи хэлний сургалтын олон зусланг зохион байгуулахад сүмийн нэгэн гишүүнд сайн дураараа тусалдаг байсан. Заах нь үнэхээр миний дуртай мэргэжил. Мэргэжлээрээ ажиллахаас гадна сүмд Тайландын Үйлчлэлийн Төвийн менежер, ХҮГ Сүмийн Сангийн ерөнхийлөгч болон түүнчлэн Бүсийн материал хангамжийн менежерээр ажиллаж байв.

Намайг жаахан байхад манай жижиг тосгонд протестант номлогчид айлчилж ирдэг байсан. Тэд бидэнд зааж бас дуулж өгдөг байлаа. Тосгоны хүмүүс тэдэнтэй мэндэлж, ярьдаг байсан учраас бүх зүйл сайхан байв. Гэвч тэднийг манай тосгонд зочлоод, явснаас хойш тосгоны хүмүүс тэдний талаар бүдүүлэг зүйлс ярьж, тэдний номлосон Есүс Христийн нэрээр тохуурхдаг болов. Энэ байдал намайг, Есүс Христийн талаар “тэр хэн бэ мөн тэд яагаад түүний талаар ийм аймшигтай зүйлүүдийг ярьж байгаа юм бол” гэх мэт олон асуултыг өөрөөсөө асуухад хүргэсэн билээ. Гэвч энэ нь намайг асуултуудынхаа хариултуудыг хүлээн автал удаан үргэлжлээгүй юм.

Ахлах сургуульд сурч байх үед манай ангийнхны нэг нь надаас “Визит, Чи Бурхан амьд гэдэгт итгэдэг үү?” гэж асуухад “Үгүй, энэ боломжгүй зүйл” гэж



Далын ахлагч
Визит Канахам

би түүнд хариулсан бөгөөд “Визит, хүн Бурхантай ярьж чаддаг гэдэгт чи итгэдэг үү” гэж түүнийг дахин асуухад би түүнд “Чи галзуу байх аа” хэмээн хариулж билээ. Би Эм Ай Эй хөтөлбөрт нэгдэж мөн номлогчдын хичээлүүдийг сонссоноор удалгүй тэдэнтэй уулзаж эхэлсэн. Хэсэг хугацааны дараа аав маань өөрийнх нь өмнөөс гарын үсэг зурахыг надад зөвшөөрөхөд би баптисм хүртэх шийдвэрээ гаргасан билээ.

Би сүмд 43 жилийн турш салбар, дүүрэг, номлол, гадасны олон өөр өөр дуудлагад үйлчлэхээр дуудагдаж байсан. Мэндлэгч байх нь надад ням гарагт шинэ хүмүүстэй мэндлэх боломж олгон, тэдэнд гэртээ байгаа мэт сэтгэгдэл төрүүлж, мөн ариун ёслолын цуглаан дээр шүтэн бишрэхэд бэлэн болоход нь тусалдаг учраас миний хамгийн дуртай үүрэгт ажлын маань нэг байв. Өмнөх хүлээн авч байсан болон чөлөөлөгдөж байсан дуудлагууд удирдагчийн чадваруудаа хөгжүүлж, сүнслэгээр өсөж хөгжихөд минь надад тусалсан юм.

Манайх Вайсотипорн гэдэг 31 настай хүү, Висүшалак гэдэг 30 настай охинтой. Миний эхнэр Сүмамаан, хүү Вайсотипорн бид 3 Тайландын Бангкок номлолд, харин охин Висүшалак маань Калифорнийн Оакланд номлолд үйлчилсэн юм. Бид буцаж ирсэн номлогч гэр бүл. Эхнэр бид хоёр саяхан гишүүд болон удирдагч ахлах номлогчдыг дэмжиж үйлчлэн, 2013 оны 10-р сард номлолоо дуусгасан. Номлолд үйлчилсэн маань бидний мөнх бус амьдралдаа хийсэн хамгийн агуу зүйл билээ.

Их Эзэн Есүс Христэд итгэх миний шинэ итгэлийг ээж минь хүлээн зөвшөөрөөгүй ч гэсэн би ээждээ маш их талархалтай байдаг. Би баптисм хүртсэнийхээ дараа гэр бүлээсээ хөөгдсөн юм. Намайг мэддэг байсан олон хүн миний итгэл, гэрчлэлийг хахир хатуу үгээр доромжилж, намайг маш их ганцаардуулж байлаа. Гэхдээ Их Эзэнийг шүтэн бишрэхэд намайг юу ч зогсоож чадаагүй. Мөн бүрэн цагийн номлолд үйлчлэхийн тулд хийж байсан бүрэн цагийн багшийн ажлаа орхихоор шийдэхэд ээж маань намайг гэр бүлээсээ хөөхөөр төлөвлөж байсан юм. Гэсэн хэдий ч амьдралд маань тохиолдсон олон сорилт, зовлон бэрхшээл миний хувьд Есүс Христэд итгэх хүчирхэг итгэл болон гэрчлэлийг бий болгосон билээ. Улмаар ХҮТ амьдралын хэв маягийн ачаар гэр бүлийг минь эцэг эх, гэр бүлийн гишүүд, хамаатан садан, хөршүүд маань хүлээн авсан юм. Ээжийг минь нас барахаас өмнө урьдын бүхий л зөрчлүүд эвлэрүүлэгдсэн байсан.

1971 онд хөрвөгдөж эхэлснээс хойш дуулгавартай байдал бол миний хувийн сүнслэг

өсөлт хөгжлийн амин чухал хэсэг нь байсан. Энэхүү чухал зарчмын ачаар Есүс Христэд итгэх итгэл болон гэрчлэл минь бага багаар өссөн юм. Тэр үед Христийн сургаалын хүссэн үр дүн ямар болж эргэж ирэх талаар ямар ч алсын хараа, дүр зураг надад байгаагүй. Гэсэн хэдий ч, хүү Исаакаа тахил болгон өргөхөөр зарлигдуулж мөн Абрахам, Исаак хоёул Бурханы хүсэлд дуулгавартай байсан талаар бүх залуу гэгээнтний хуваалцсан, хүн бүхний сайн мэддэг судрын түүх нь бодит бөгөөд энэ түүх үлгэр биш гэдэг нь миний зүрх сэтгэлд батлагдсан юм. “Мөнхүү улиран тохиох дор эдгээр зүйлийн дараа Бурхан Абрахамыг шалгаж, туршихаар түүнийг дуудаж, Абрахам аа, гэсэнд Абрахам Би энд байна гэжээ. Бурхан чи өөрийн хүү, цорын ганц хайртай хүү Исаакаа аваад Мориа гэдэг газар руу яв. Миний зааж өгөх нэгэн уулан дээр, тэндээ түүнийг шатаалт тахил болгон өргө гэв. . .”¹ Дуулгавартай байдал нь үйлдэл рүү хөтөлдгийг би мэдэж авсан. Би баптисм хүртсэнийхээ дараа Их Эзэний намайг хийгээсэй хэмээн хүсдэг зүйлийг үргэлж санадаг. Би суралцахын хэрээр судрууд дахь илчлэлтүүд нь, ялангуяа “энэ нь тулгуурлагдсан тэрхүү хуульд дуулгавартай байснаар буюу”² хэмээх зарчим нь үнэн гэдэгт Ариун Сүнсээр сэнхрүүлэгдсэн билээ.

Би Сүмийн шинэ хөрвөгчдийг харах бүрдээ шинэ хөрвөгч байснаа санадаг. Надад сүмийн судрууд болон сургаалын талаар гүн гүнзгий мэдлэг байгаагүй. Би зөвхөн итгэлээ дагаж урагшилсан. Сүмийн шинэ хөрвөгчид дуулгавартай байснаар өсөж хөгжин,

амьдралдаа сайн мэдээний адислалуудыг хүлээн авах болно гэсэн бүрэн дүүрэн итгэл найдвар надад байдаг. Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смитийн тунхагласнаар “би зарлигуудыг дагаж, зөв шударгын ажлуудыг хийн, бидний удирдагч, жишээ үзүүлэгч болон бүхний тэргүүн Есүсийг дагаж, Их Эзэний хуулиудад дуулгавартай байснаар үүнийг олж чадна гэдгийг мэднэ.”³

Би баптисм хүртсэнээсээ хойш 10 зарлигийг чадахынхаа хэрээр дагаж байна. Би хүндэтгэлийн өдөр бүр ариун ёслолоосоо хүртэн, аравны нэгээ бүрэн төлж, сүмдээ хүсэлтэйгээр үйлчлэн, судруудаас суралцаж, залбиран, гэр бүлийн үдэштээ оролцож, амьдралын бүх л энгийн зүйлүүдийг үргэлжлүүлэн хийж байна. Эцэст нь, дуулгавартай байдал 2 агуу зүйл шаарддагийг би өөртөө баталсан юм. “Болгоогтун, Их Эзэн зүрх сэтгэл хийгээд эрмэлзэгч оюуныг шаарддаг . . .”⁴ бөгөөд би хэзээ ч Их Эзэний намайг хийхийг хүссэн зүйлийг үл тоомсорлодоггүй. Түүнчлэн “. . . сайныг үйлдэхэд шантрамттай бүү бай, . . . Мөн агуу болох тэрхүү зүйл жижиг зүйлүүдээс гарч ирдэг.”⁵ Энэ сүм үнэн бөгөөд Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга нь Бурханаас дуудагддаг гэдгийг би гэрчилж байна. Их Эзэний арга замаар дуулгавартай байснаар бид адислагдах болно. Есүс Христийн нэрээр, Амен. ■

NOTES:

1. Эхлэл 22:1-13, 16-18-ыг үзнэ үү.
2. С ба Г 130:21-ийг үзнэ үү.
3. *Teaching Presidents of the Church: Joseph Fielding Smith* (2013), 229.
4. С ба Г 64:34-ийг үзнэ үү.
5. С ба Г 64:33-ыг үзнэ үү.

СҮМИЙН ЗАЛУУЧУУД ҮЙЛЧЛЭЛ ХИЙВ

Орон нутгийн мэдээний редактор Тогтохын Энхтүвшин

Сүмийн ганц бие залуучууд Баянзүрх дүүргийн Хүүхдийн сувиллын цэцэрлэгийн гаднах орчинг цэцэг тарьж тохижуулав. Энэ төслийг Олон улсын Дезерет Энэрлийн Байгууллага санхүүжүүлсэн байна. Залуучууд идэвх санаачлагатай оролцсон бөгөөд ажил дуусахад цэцэрлэгийн орчин тойрон гоёмсог харагдаж байв. Тус цэцэрлэгийн захирал Туул өөрийн хамт олны зорилго, үйл ажиллагааны талаар залуучуудад дэлгэрэнгүй танилцуулав. Тус цэцэрлэг нь бага насны хүүхдүүдийг асарч сувилан хүмүүжүүлдэг бөгөөд мөн эцэг эхчүүдэд хүүхдүүдээ яаж арчилж, сувилах талаар сургалт явуулдаг байна. Цэцэрлэгийн захирал залуучуудын хүмүүнлэгийн тусламж, үйлчлэлд чин сэтгэлийн талархлаа илэрхийлсэн юм. ■



Залуучууд үйлчлэл хийж байгаа нь



Ажлын дараа

Өсвөр үеийнхний чуулган—2014



Хоолондоо

2014 оны 6-р сарын 25-наас 28-ны өдрүүдэд Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн 360 гаруй өсвөр үеийнхэн Улаанбаатар, Налайх, Дархан, Багануур, Эрдэнэт, Булган, Сэлэнгэ, Зүүнхараагаас нэгэн дор цугларч, чуулганаа зохион байгуулав. Тэд төмөр замаар аялан, Мандал өртөөнд бууж, халуун наранд намаг шалбааг гатлан, 10 км явган алхсаны эцэст үзэсгэлэнт Баян голын эрэг дээр буудалласан юм. Тэд уулын энгэрт майхнаа эгнүүлэн барьж, Бенжамин хааны цамхгийг босгосон нь Мормоны Номон дахь тэр түүхэн үеийг өөрийн эрхгүй санагдуулж байв. . . .

Нэн ялангуяа, тойрог, номлол, дүүргийн санваарын удирдагчид эртний өмсгөлтэй

цамхаг дээр гарч үг хэлэх үед бидэнд тэр үе рүү эргэн очсон мэт санагдаж байв. Гадасны ерөнхийлөгч Одгэрэл цамхаг дээр гарч ирэн “би хэн бэ?” гэхэд бүгд нэгэн дуугаар Одгэрэл ах байна гэж хэлсэн ч хүн бүр дор бүрнээ нээрээ энэ чинь хэн билээ? хэмээн гайхах зуур “Үгүй ээ, би Бенжамин байна” гэхэд бид баясан, Ариун Сүнсээр дүүрч билээ. . . .

Тийм ээ, байнга уншиж, судалж байдаг тэр домогт бошиглогчдынхоо үгийг гурван өдрийн турш “амьдаар сонсох” сайхан, сүнслэг мөч бидэнд тохиосон юм.

Тийм ээ, үзэсгэлэнт Монгол орны минь бахархал болсон Хан Хэнтийн ноён оргилууд хөхрөн харагдсан энэхүү голын хөндийд эртний



Бенжамини цамхаг



Цугларалт

бошиглогчид өнөө үеийн санваартнуудаар дамжуулан өсвөр үеийнхэнд хандан Бурханы үгийг болон өөрсдийн захиасыг үлдээсэн юм.

Энэ өдрүүдэд, өсвөр үеийнхэн өртөөчилсэн спорт тоглоом тоглож, судрын сэдвээр олон бэсрэг жүжиг найруулан тавьсан бөгөөд мөн АХА тэмцээн зохиосон юм. Баянзүрх салбарын гишүүн Бадамгэрэл, Жаргалант салбарын гишүүн Цэцгээ нар АХА тэмцээнд судрын мэдлэгээрээ шалгарч, найз нөхдийнхөө бахархал нь болцгоов.

Энэ өдрүүдэд газар газраас ирсэн охид хөвгүүд дотносож, сайн найз нөхөд болсон бөгөөд тэд галын дэргэдэх цугларалтад оролцоходоо зохистой хувцсаар жигдрэн, ширүүн бороог ч үл ажран сууж байсан нь Тэнгэрлэг

Эцэгээ хүндэтгэх, дуулгавартай байхын үлгэр жишээ болов.

Чуулганы зорилго ч ийм байсан болой. Чуулган өндөрлөх өдөр Номлолын ерөнхийлөгч Бенсон өсвөр үеийнхэнд хандаж, ганц хоёроороо уулын оргилд хүрэхэд бэрх, нэг нь унахад нөгөөдөх нь татан авч дийлэхгүй байж болно, харин дөрвүүлээ болон түүнээс ч олуулаа байвал нэг нэгэндээ туслахад илүү хялбар, тэр байтугай ангалаас ч татан авч чадах бөгөөд үүний нэгэн адил өсвөр үеийнхэн Сүмдээ найз нөхөд байх нь маш чухал, тэд нэг нэгнээ түшсэнээр амжилтанд хүрч, идэвхгүй нэгнээ Сатаны савраас татан авч чадна гэдгийг анхааруулан захисан билээ. ■

Хөгжөөнт тоглоом



ДЕЗЕРЕТ ОЛОН УЛСЫН ЭНЭРЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС

Эмчилгээний тоног төхөөрөмж бэлэглэв

Ахлагч Нэй ба систер Нэй

Тус байгууллага нь Хөвсгөл аймгийн Мөрөн хотод байрлах Эрүүл мэндийн нэгдэлд эмчилгээний зориулалттай гурван тоног төхөөрөмж бэлэглэв. Үүнд: бэртсэн булчин, шөрмөс, холбоосыг эмчлэхэд дэм үзүүлдэг хэт авианы физик эмчилгээний аппарат; ясны хугарал, бороололтыг түргэсгэх соронзон эмчилгээний аппарат; хэрх өвчин, хүзүүний өвчин зэрэг үе мөчний болон нурууны гэмтлийн үрэвсэл, өвчинг намдаах аппарат орно.

Өмнө нь ийм аппарат хэрэгсэл байгаагүй учир орон нутгийн өвчтөнүүд 675 километр зам туулан, Улаанбаатарт ирж эмчлүүлдэг байжээ. Тус эмнэлгийн ажилтнууд эдгээр эмчилгээний аппарат нь өвчтэй хүмүүст маш их тус болно гээд гүн талархлаа илэрхийлсэн юм

Ахлагч Энгланд гэргийн хамт ДОУЭБ-ыг төлөөлөн энэ ёслолд оролцов. ■



Эмчилгээний аппарат гардуулах ёслол дээр



Үе мөчний эмчилгээний аппарат гардуулж байгаа нь



Соронзон эмчилгээний аппарат гардуулж байгаа нь



Хэт авианы эмчилгээний аппарат гардуулж байгаа нь